



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 17 өдөр

Дугаар А/506

Булган сум

Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 19 дүгээр хуралдааны XIX/08 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 2.15 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Алтаргана 2024” олон улсын XV их наадмын Бөхийн тэмцээний үнэмлэхүй аварга, Хурдан их насны морь, Буриад сурын бай шагналд шаардагдах 3 ширхэг суудлын автомашин худалдан авахад 177,000,000 (нэг зуун далан долоон сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Автомашины нийлүүлэгчээр Geely брэндийн албан ёсны дистрибьютер “Таван богд моторс” ХХК-ийг сонгож гэрээ шууд байгуулан, барааны нийлүүлэлт, гүйцэтгэлд холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д даалгасугай.

3.Гэрээнд заагдсан барааг холбогдох хууль, журмын дагуу тогтоосон хугацаанд чанартай нийлүүлэхийг “Таван богд моторс” ХХК-ийн гүйцэтгэх захирал (П.Буяндэлгэр)-д үүрэг болгосугай.

4.Дээрх хөрөнгийг орон нутгийн хөгжлийн сангийн “Алтаргана 2024” арга хэмжээний төлөвлөгдсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6324010716